



25

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот



Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 8 дугаар зүйл, Монгол улсын Засгийн газраас 2013 оны 03 дугаар сарын 02-ны өдөр “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Агаарын чанарын албаны Хяналт, үнэлгээний хэлтсийн хэрэгцээнд ашиглагдаж буй Тесто 350 XL-454 яндангийн утааны зөөврийн 2 ширхэг багажийн сэлбэг хэрэгслүүдийг шинээр нийлүүлэх болон стандарт хийгээр тохиргоо хийлгүүлэх ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн Үнэлгээний хороог доорх бүрэлдхүүнтэйгээр томилон ажиллуулсугай.

Дарга: Х.Галымбек /Нийслэлийн Агаарын чанарын албаны дэд дарга/

Гишүүд: Г.Баярхүү /Нийслэлийн Агаарын чанарын албаны БХТХ-ийн дарга/
Э.Дөлгөөн /Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн/ зөвшилцсөнөөр
З.Болдбаатар /"Монголын ногоон хөгжлийн зуун" ТББ-ын гишүүн/ зөвшилцсөнөөр

Нарийн бичгийн дарга: Б.Баясгалан /Нийслэлийн Агаарын чанарын албаны мэргэжилтэн/

2. Тендер сонгон шалгаруулах үйл ажиллагааг харьцуулалтын аргаар бараа худалдан авах төсөвт өртөгт нийцүүлэн сонгон шалгаруулж, танилцуулахыг Үнэлгээний хороо /Х.Галымбек/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.БАТСАЙХАН

1150500005